БАТЛАВ
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ДАРГА П.МӨНХЖАРГАЛ

2021 оны ...06... дугаар сарын ...04...-ны өдөр

ӨНДӨР ХУРДНЫ ИНТЕРНЕТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэ техникийн тодорхойлолт нь Иргэний нисэхийн үндэсний төвд өндөр хурдны интернетийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай техникийн үзүүлэлтүүдийг тусгасан болно.

2. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Өндөр хурдны интернетийн үйлчилгээ үзүүлэх байгууллага нь дараах техникийн шаардлагыг бүрэн хангасан байна.

Д/Д	Үйлчилгээ, нэр, төрөл	Тавигдах шаардлага
1	Олон улсын гарц	Бие биенээсээ үл хамаарах үндсэн, нөөц гарцтай байх ба АНУ, Европ, Азийн үндсэн урсгалын зангилаа төвүүдэд шууд хандалттай байх.
2	Олон улсын гарцын холболт	Аль нэг чиглэлд интернет порт болон шилэн кабелийн сүлжээнд гэмтэл гарах үед өөр хоорондоо автоматаар шилжих 1+1 Best Path Back up BW хамгаалалттай байх.
3	Холболтын төрөл, протокол	Шилэн кабель, BGP протоколоор холбогдох бүрэн боломжтой байх.
4	Холболтын хурд	206Mbps (dedicated) буюу түүнээс дээш үзүүлэлттэй байх
5	Холболтын хийх байршил	Монголын цахилгаан холбоо ХК-ний Төв байрны 4-р давхарт байрлах ИНҮТ-ын тоног төхөөрөмжийн зогсуурт холбох
6	Холболтын интерфейс	Нийлүүлэгч тал болон ИНҮТ хооронд үндсэн холболтыг яармаг чиглэлийн шилэн кабелаар, нөөц холболтыг Сонсголон чиглэлийн шилэн кабелаар хийх порттой байх. 40км зайд GBIC модулиар дамжуулах техникийн шийдэлтэй байх.
7	Техникийн үйлчилгээ	24/7 горимоор техникийн үйлчилгээ үзүүлэх, хамтарч ажиллах.
8	Хяналт	Үндсэн интернет урсгалын хяналтыг нийлүүлэгч талаас хянах /PRTG&MRTG, Cacti...../ хэрэглэгчийн эрх ХНАА-ны хариуцсан инженерт нээж өгөх.
9	Тусгай зөвшөөрөл	Албан ёсны интернетийн бөөний үйлчилгээ үзүүлэх А ангиллын тусгай зөвшөөрөлтэй байх. Сүүлийн 5 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулсан байх.
10	Халдлагаас хамгаалах систем	Ddos болон бусад халдлагаас хамгаалагдах, тэдгээрийн тайланг тогтмол авах боломжтой байх.
11	Интернетийн гарц	Ямар нэг контент нөөцлөх системээр дайрахгүй байх
12	Интернет урсгал	Интернэтийн урсгалын хурдыг нэмэгдүүлэх болон багасгах асуудлыг ажлын 1 өдөрт багтаан шийдвэрлэх.

13	Монгол улсаас гарах нөөц холболтын шаардлага	Аль нэг гадаад гарц унасан тохиолдолд нөөц холболт нь үндсэн урсгалыг бүрэн хангах чадвартай байх ба энэ шаардлагыг биелүүлэх техникийн шийдлийг ирүүлэх.

3. БАРИМТ БИЧИГ

Дараах бичиг баримтуудыг ирүүлнэ. Үүнд:

3.1 Албан ёсны интернетийн бөөний үйлчилгээ үзүүлэх А ангиллын тусгай зөвшөөрлийн гэрчилгээ
3.2 Өөрийн байгууллагын үйлчилгээний танилцуулга
3.3 Холболтын диаграм зураг

4. ХОЛБОЛТ, ТУРШИЛТ

4.1 Интернет урсгалын холболтын ажил хийгдсэний дараа ажиллагааг шалгах тестийг Иргэний нисэхийн үндэсний төвд 7 хоногийн туршилтын ажлыг хийнэ.
4.2 Нийлүүлэгч нь зөвхөн шаардлагад нийцсэн өндөр хурдны интернетийн үйлчилгээ үзүүлэх ба холболтын ажлыг Иргэний нисэхийн үндэсний төвийн ХНАА-ны ажилтнуудтай хамтарч гүйцэтгэнэ.

5. ТУРШИЛТЫН АЖЛЫН ХУВААРЬ.

№	Хийгдэх үйлчилгээ	Огноо
1	Туршилт шалгалт эхлэх	2021.12.16
2	Үндсэн сүлжээг холбож үйлчилгээ эхлэх	2021.12.25
3	Үйлчилгээг дуусгах	2022.12.25

6. ХҮЛЭЭН АВАХ

6.1 Нийлүүлэгч тал нь техникийн үзүүлэлтэд нийцсэн програм хангамжийг нийлүүлж суурилуулна.
6.2 ИНҮТ-ийн даргын тушаалаар томилогдсон ажил хүлээн авах комисс нь техникийн тодорхойлолтын дагуу техникийн үзүүлэлт болон системийг шалгаж, ажил хүлээн авах актыг үйлдсэнээр барааг хүлээн авсанд тооцно.
6.3 Баталгаат засварын хугацаа нь ажил хүлээн авах комисс нь хүлээн авах баримтанд гарын үсэг зурж, хүлээн авснаас хойш 12 сар.
6.4 Ачааг авах цэг ИНҮТ.

ТАНИЛЦСАН:
АГААРЫН НАВИГАЦИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Э.ТӨРБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА
ХОЛБОО, НАВИГАЦИ, АЖИГЛАЛТЫН АЛБАНЫ ДАРГА М.ЭРДЭНЭСҮХ

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ТАСГИЙН МЭРГЭЖИЛТЭН С.НАРАНБААТАР

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ГИШҮҮД

ХОЛБОО, НАВИГАЦИ, АЖИГЛАЛТЫН АЛБАНЫ
ХОЛБООНЫ ХЭСГИЙН ДАРГА Э.БУЛГАН

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЗАЛУУЧУУДЫН
ХОЛБООНЫ ГИШҮҮН Г.ЭНХТҮВШИН

“ОД ХӨГЖИЛ” ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН
ТЭРГҮҮН Л.АЛТАН-ОД